



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/219

Мандалговь

Эзэмшил газрын хэмжээг өөрчилж,
нэгж талбарыг нэгтгэх тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 31 дүгээр зүйлийн 31.2, эзэмшил газраа нэгтгэж гэрчилгээ авах иргэний хүсэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сайнцагаан сумын 9 дүгээр багийн нутаг дэвсгэрт иргэн Санждоржийн Ням (ЗЮ83102821)-ийн худалдаа, үйлчилгээний зориулалттай (Их тойруу 7-715)-т байршилтай 2000 м.кв (0.2 га), (Их тойруу 7-719)-т байршилтай 600 м.кв (0.06 га), Тэс петролиум ХХК-ний ШТС-ын зүүн талд байршилтай 1600 м.кв (0.16 га) эзэмшил газруудыг нэгтгэж талбайн хэмжээг 5824 м.кв (0.58 га) болгон өөрчилж, зориулалтаар нь 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигчийн газрын гэрчилгээг олгож, газар эзэмших гэрээ байгуулж ажиллахыг газрын даамал (Л.Хулан), хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Ж.Миеэсүрэн) нарт даалгасугай.

3. Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зориулалтын дагуу эзэмшиж, газрын төлбөрөө цаг тухайд нь төлж байхыг газар эзэмшигч (С.Ням)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн А/151 дүгээр захирамж, 2021 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/58 дугаар захирамж, 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/209 дүгээр захирамж мөн газар эзэмших эрхийн 000025219, 000120293, 0000021249 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

С.БАТ-ОРГИЛ